



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/361

Мандалговь

Аймгийн “Шилдэг багш” шалгаруулж,  
урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4, аймгийн Засаг даргын 2017 оны А/407 дугаар захирамжаар батлагдсан “Шилдэг төрийн албан хаагч шалгаруулж, урамшуулах журам”-ын 4.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн 2019 оны “Шилдэг багш”-аар нэр бүхий 6 багшийг журмын дагуу шалгаруулж, тус бүр өргөмжлөл, 1000000 төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

Хоёр. “Шилдэг багш”-аар шалгарсан багш нарын нэрсийг 1 дүгээр, урамшууллын зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Шагналын зардалд шаардагдах 6.324.000 (зургаан сая гурван зуун хорин дөрвөн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ


488191020

Аймгийн Засаг даргын 2019 оны  
10 дугаар сарын 04-ний өдрийн 136/ дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт

ШИЛДЭГ БАГШААР ШАЛГАРСАН БАГШ НАРЫН НЭРС

№	Овог нэр	Албан тушаал
1	Жууяарын Долгосүрэн	"Эрдмийн Далай" цогцолбор сургуулийн физикийн багш
2	Төмөрбаатарын Мөнхбат	"Цэгц билэг" сургуулийн түүх нийгмийн багш
3	Эрдэнэбатын Тогоохүү	"Говийн ирээдүй" цогцолбор сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
4	Пүрэвдоржийн Болормаа	Эрдэнэдалай сумын ЕБС-ийн математикийн багш
5	Аръяагийн Цогбадрах	МСҮТ-ийн мужааны багш
6	Батнасангийн Гандулам	Сайнцагаан сумын 3 дугаар цэцэрлэгийн туслах багш

Аймгийн Засаг даргын 2019 оны  
10 дугаар сарын 04-ний өдрийн 108/1 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт



ШИЛДЭГ БАГШ УРАМШУУЛАХ, УРАМШУУЛЛЫН ЗАРДАЛ

№	Зардлын утга	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Урамшуулал	6	6000000	6000000
2	Өргөмжлөл	6	48000	288000
3	Батламж	6	6000	36000
	ДҮН			6324000